



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/003/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2026 оны 02 дүгээр сарын 20</p> <p>2026</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Даваадорж</p> <p>Утас: 90119422 Цахим хаяг: Davaadorjd@audit.gov.mn</p>
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА**

2026.02.24 № 2/36
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд Улсын санхүүжилтээс 4,7621,650.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,7621,650.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 11 төрлийн 179,059м² газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 2 газрын хэмжээ 85м²-аар байгууллагын балансад бүртгэлтэй хэмжээнээс зөрүүтэй байна.

6426050110

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 97.8 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,224,557,268.42</u>	<u>1,330,530,026.98</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	52,772,000.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	52,772,000.00	00.00
3121	Төгрөг	52,772,000.00	00.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	52,772,000.00	00.00
33	АВЛАГА	30,000,000.00	19,973,800.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	19,973,800.00
335	Бусад авлага	30,000,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	30,000,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,141,785,268.42	1,310,556,226.98
351	Түүхий эд материал	2,429,022.27	27,623,322.27
35110	Тусгай зориулалттай материал	1,753,827.27	1,664,727.27
35130	Эм боох материал	675,195.00	25,958,595.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	114,529,961.00	00.00
354	Хангамжийн материал	787,335,286.15	1,120,559,827.71
35410	Бичиг хэргийн материал	1,082,540.00	1,235,940.00
35420	Аж ахуйн материал	34,099,115.88	36,291,459.88
35430	Сэлбэг хэрэгсэл	47,908,384.00	54,481,884.00
35440	Түлш, шатах тослох материал	44,978,420.00	6,490,780.00
35450	Барилгын засварын материал	00.00	29,205.70
35460	Хүнсний материал	105,000.00	1,300.00
35600	Мал амьтад	2,100,000.00	2,100,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,167,357,674.40</u>	<u>5,528,319,403.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,167,357,674.40	5,528,319,403.38
392	Биет хөрөнгө	2,475,483,114.40	4,818,849,843.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,321,193,959.64	1,338,082,959.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-745,919,493.76	-792,929,570.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,628,508,109.30	7,760,002,109.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	2,873,065,583.13	-3,624,011,860.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	431,233,746.00	439,441,134.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-289,630,970.81	-304,683,215.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,652,455.98	31,352,455.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,489,108.82	-28,404,169.12
393	Биет бус хөрөнгө	691,874,560.00	709,469,560.00
39301	Програм хангамж	1,525,000.00	1,525,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,525,000.00	-1,525,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	691,874,560.00	709,469,560.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,391,914,942.82</u>	<u>6,858,849,430.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>1,100,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>1,100,000.00</u>

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
413	Өглөг	00.00	1,100,000.00
4136	Бусад өглөг	00.00	1,100,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,100,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,391,914,942.82	6,857,749,430.36
51	Засгийн газрын хувь оролцоо	4,391,914,942.82	6,857,749,430.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,156,582,358.27	1,156,582,358.27
51101	Өмч: - төрийн	1,156,582,358.27	1,156,582,358.27
512	Хуримтлагдсан үр дүн	2,869,269,504.58	5,336,580,713.12
51210	Өмнөх үеийн үр дүн	2,869,269,504.58	2,870,746,225.58
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,465,834,487.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	366,063,079.97	364,586,358.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,391,914,942.82	6,858,849,430.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,272,409,275.00	8,759,898,680.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,163,578,555.00	3,904,460,818.18
120	Нийтлэг татварын бус орлого	1,163,578,555.00	3,904,460,818.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,110,806,555.00	3,904,460,818.18
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,110,806,555.00	3,904,460,818.18
120009	Бусад орлого	52,772,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,108,830,720.00	4,855,437,862.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,080,491,700.00	4,788,600,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,080,491,700.00	4,788,600,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,339,020.00	66,837,462.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,906,962.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,535,500.00	44,640,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,803,520.00	17,290,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,138,949,689.33	6,261,939,192.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,138,949,689.33	6,261,939,192.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,096,990,152.90	6,230,589,670.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,504,296,051.00	4,186,334,885.00
210101	Үндсэн цалин	2,268,663,898.00	2,709,435,924.00
210102	Нэмэгдэл	1,066,668,853.00	1,240,542,961.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	87,983,500.00	121,312,000.00
210104	Урамшуулал	80,979,800.00	115,044,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,247,728.97	113,294,448.42
210201	Тэтгэврийн даатгал	21,006,425.97	24,537,048.42
210202	Тэтгэмжийн даатгал	2,447,153.00	2,922,058.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,881,748.00	2,248,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	438,782.00	524,714.00
210205	Эрүүл мэндийн даатгал	68,473,620.00	83,062,528.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,058,257.53	247,434,156.43
210301	Гэрэл, цахилгаан	19,110,907.53	25,641,193.43
210302	Түлш, халаалт	199,417,210.00	215,441,123.00

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210303	Цэвэр, бохир ус	5,530,140.00	6,351,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	167,691,446.07	198,979,559.57
210401	Бичиг хэрэг	3,964,000.00	8,969,200.00
210402	Тээвэр, шатахуун	147,462,670.00	141,000,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,814,106.07	5,246,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,883,600.00	18,902,500.00
210408	Бараа материал акталсны зардал	5,067,070.00	23,360,419.57
2105	Нормативт зардал	166,373,526.74	310,500,647.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,100,915.00	14,700,200.00
210502	Хоол, хүнс	70,519,150.00	117,415,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	94,753,461.74	178,384,647.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	138,271,512.00	104,347,712.05
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,267,480.00	37,093,000.00
210604	Урсгал засвар	136,004,032.00	67,254,712.05
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,942,385.00	187,988,411.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,999,240.00	180,062,461.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	537,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,249,836.00	2,693,448.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	759,000.00	694,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,058,300.00	947,000.00
210807	Газрын төлбөр	3,276,009.00	3,054,002.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	718,309,245.59	881,709,851.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,000,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,715,000.00	36,564,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	703,594,245.59	845,145,751.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,959,536.43	31,349,522.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,300,000.00	5,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,300,000.00	5,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,659,536.43	25,949,522.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,659,536.43	25,949,522.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	133,459,585.67	2,497,959,487.54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	32,125,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,125,000.00
225002	Найдваргүй авлагын алдагдал	00.00	30,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-32,125,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	133,459,585.67	2,465,834,487.54

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,161,602,720.00	4,855,437,862.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,772,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	52,772,000.00	00.00
120009	Бусад орлого	52,772,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,108,830,720.00	4,855,437,862.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,080,491,700.00	4,788,600,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,080,491,700.00	4,788,600,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,339,020.00	66,837,462.00

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,906,962.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,535,500.00	44,640,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,803,520.00	17,290,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,107,925,820.00	4,906,419,862.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,107,925,820.00	4,906,419,862.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,065,966,283.57	4,856,196,539.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,504,296,051.00	4,186,334,885.00
210101	Үндсэн цалин	2,268,663,898.00	2,709,435,924.00
210102	Нэмэгдэл	1,066,668,853.00	1,240,542,961.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	87,983,500.00	121,312,000.00
210104	Урамшуулал	80,979,800.00	115,044,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,247,728.97	113,294,448.42
210201	Тэтгэврийн даатгал	21,006,425.97	24,537,048.42
210202	Тэтгэмжийн даатгал	2,447,153.00	2,922,058.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,881,748.00	2,248,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	438,782.00	524,714.00
210205	Эрүүл мэндийн даатгал	68,473,620.00	83,062,528.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,534,382.53	248,706,156.43
210301	Гэрэл, цахилгаан	19,110,907.53	25,641,193.43
210302	Түлш, халаалт	198,893,335.00	216,713,123.00
210303	Цэвэр, бохир ус	5,530,140.00	6,351,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,086,706.07	23,022,700.00
210401	Бичиг хэрэг	2,889,000.00	1,798,100.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	11,110,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,814,106.07	5,246,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,883,600.00	3,368,000.00
2105	Нормативт зардал	71,530,150.00	105,554,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,086,000.00	2,017,600.00
210502	Хоол, хүнс	70,444,150.00	103,537,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,630,000.00	36,619,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,980,000.00	1,792,500.00
210604	Урсгал засвар	110,650,000.00	34,826,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,481,265.00	106,100,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,538,120.00	98,174,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	537,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,249,836.00	2,693,448.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	759,000.00	694,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,058,300.00	947,000.00
210807	Газрын төлбөр	3,276,009.00	3,054,002.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,360,000.00	36,564,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,360,000.00	36,564,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,959,536.43	50,223,322.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,300,000.00	4,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,300,000.00	4,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,659,536.43	45,923,322.15

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,659,536.43	45,923,322.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	53,676,900.00	-50,982,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	904,900.00	1,790,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	904,900.00	1,790,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	904,900.00	1,790,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	904,900.00	1,790,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-904,900.00	-1,790,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	52,772,000.00	-52,772,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	52,772,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	52,772,000.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	400,042,860.19	216,528,453.86	863,022,001.47	00.00	1,479,593,315.52
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,739,176.06	00.00	5,739,176.06
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	400,042,860.19	216,528,453.86	868,761,177.53	00.00	1,485,332,491.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-5,739,176.06	00.00	00.00	-5,739,176.06
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	53,373,696.66	00.00	53,373,696.66
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	366,063,079.97	2,869,269,504.58	00.00	4,391,914,942.82
D01	2025 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	366,063,079.97	2,869,269,504.58	00.00	4,391,914,942.82
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,476,721.00	00.00	1,476,721.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,156,582,358.27	366,063,079.97	2,870,746,225.58	00.00	4,393,391,663.82
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,476,721.00	00.00	00.00	-1,476,721.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,465,834,487.54	00.00	2,465,834,487.54

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,156,582,358.27	364,586,358.97	5,336,580,713.12	00.00	6,857,749,430.36
-----	---------------------------------------	------------------	----------------	------------------	-------	------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,788,600,400.00	4,762,650,877.85	25,949,522.15	99.5
Улсын төсвөөс санхүүжих	4,788,600,400.00	4,762,650,877.85	25,949,522.15	99.5
Ажиллагчидтай холбогдсон зардал	4,298,413,800.00	4,294,722,371.42	3,691,428.58	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,181,537,700.00	4,181,427,923.00	109,777.00	100.0
Үндсэн цалин	2,572,822,800.00	2,709,435,924.00	136,613,124.00	105.3
Нэмэгдэл	1,419,335,600.00	1,235,635,999.00	183,699,601.00	87.1
Унаа хоолны хөнгөлөлт	74,335,200.00	121,312,000.00	-46,976,800.00	163.2
Урамшуулал	115,044,100.00	115,044,000.00	100.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,876,100.00	113,294,448.42	3,581,651.58	96.9
Тэтгэврийн даатгал	15,708,800.00	24,537,048.42	-8,828,248.42	156.2
Тэтгэмжийн даатгал	2,902,900.00	2,922,058.00	-19,158.00	100.7
ҮОМШӨ-ний даатгал	14,087,300.00	2,248,100.00	11,839,200.00	16.0
Ажилгүйдлийн даатгал	1,408,400.00	524,714.00	883,686.00	37.3
Эрүүл мэндийн даатгал	82,768,700.00	83,062,528.00	-293,828.00	100.4
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	487,413,500.00	464,628,506.43	22,784,993.57	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	266,116,900.00	248,706,156.43	17,410,743.57	93.5
Гэрэл, цахилгаан	26,182,800.00	25,641,193.43	541,606.57	97.9
Түлш, халаалт	233,494,700.00	216,713,123.00	16,781,577.00	92.8
Цэвэр, бохир ус	6,439,400.00	6,351,840.00	87,560.00	98.6
Хангамж, бараа материалын зардал	23,295,400.00	23,001,700.00	293,700.00	98.7
Бичиг хэрэг	1,895,500.00	1,777,100.00	118,400.00	93.8
Тээвэр, шатахуун	11,110,000.00	11,110,000.00	00.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,246,600.00	5,246,600.00	00.00	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,675,200.00	1,500,000.00	175,200.00	89.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,368,100.00	3,368,000.00	100.00	100.0
Нормативт зардал	105,554,700.00	105,554,700.00	00.00	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,017,600.00	2,017,600.00	00.00	100.0
Хоол, хүнс	103,537,100.00	103,537,100.00	00.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	26,587,500.00	26,587,500.00	00.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,792,500.00	1,792,500.00	00.00	100.0
Урсгал засвар	24,795,000.00	24,795,000.00	00.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,801,000.00	24,720,450.00	1,080,550.00	95.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,794,700.00	16,794,500.00	200.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	537,500.00	537,500.00	00.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	2,890,200.00	2,693,448.00	196,752.00	93.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	829,700.00	694,000.00	135,700.00	83.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	948,900.00	947,000.00	1,900.00	99.8
Газрын төлбөр	3,800,000.00	3,054,002.00	745,998.00	80.4

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	40,058,000.00	36,058,000.00	4,000,000.00	90.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,058,000.00	36,058,000.00	4,000,000.00	90.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,075,000.00	3,300,000.00	2,775,000.00	54.3
Бусад урсгал шилжүүлэг	6,075,000.00	3,300,000.00	2,775,000.00	54.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,075,000.00	3,300,000.00	2,775,000.00	54.3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,791,902,300.00	4,762,650,877.85	29,251,422.15	99.4
УРСГАЛ ЗАРДАЛ	4,791,902,300.00	4,762,650,877.85	29,251,422.15	99.4
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,785,827,300.00	4,759,350,877.85	26,476,422.15	99.4
АЖИЛЛАГСАДЫН ТОО	135.00	131.00	04.00	97.0
Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	134.00	130.00	04.00	97.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	135.00	131.00	04.00	97.0
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	126.00	123.00	03.00	97.6
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	09.00	08.00	01.00	88.9

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	82,142,462.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,142,462.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,142,462.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,906,962.00
210102	Нэмэгдэл	4,906,962.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,000.00
210401	Бичиг хэрэг	21,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,031,900.00
210604	Урсгал засвар	10,031,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,676,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,676,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	506100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	506,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1000000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	82142462.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,142,462.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,906,962.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,945,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,290,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Онцгой байдлын газар нь Урьдчилан сэргийлэх тасаг, Гал түймэр унтраах, аврах 16 дугаар анги, Гал түймэр унтраах, аврах 72 дугаар анги, Жаргалант сум дахь Эрэн хайх, аврах салбар, Улсын нөөцийн 127 дугаар салбар, Баянхонгор сум дахь Эрэн хайх, аврах бүлэг, Баянцагаан сум дахь Эрэн хайх, аврах бүлэг, Баянговь сум дахь Эрэн хайх, аврах бүлэг зэрэг нийт найман салбар нэгжийн бүтэц, зохион байгуулалтын дагуу батлагдсан орон тоонд багтан үйл ажиллагаагаа хэвийн явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийн ОБЕГ-ын дотоод хяналт шалгалтын газар хэрэгжүүлдэг ба тайлант онд хийгдсэн шалгалтаар 90.1 хувьтай дүгнэгдэж улсын хэмжээнд салбартаа нэгдүгээр байранд орсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ОБЕГ-ын даргын 2016.12.15-ний өдрийн А/293 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 6,858,849.4 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 2,466,934.5 мянган төгрөгөөр буюу 56.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	52,772.00	-	(52,772.00)
Авлага	30,000.00	19,973.80	(10,026.20)
Бараа материал	1,141,785.27	1,310,556.23	168,770.96
Үндсэн хөрөнгө	7,105,987.83	10,279,873.22	3,173,885.39
Хуримтлагдсан элэгдэл	(3,938,630.16)	(4,751,553.82)	(812,923.66)
Нийт хөрөнгө	4,391,914.94	6,858,849.43	2,466,934.49
Өр төлбөр	-	1,100.00	1,100.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,391,914.94	6,857,749.43	2,465,834.49
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,391,914.94	6,858,849.43	2,466,934.49

Эх сурвалж: Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0 болж өмнөх оноос 52,772.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онд ахмадын сангийн үлдэгдэл 52,772.0 мянган төгрөг байсан бөгөөд тайлант онд ахмадын сангаас 32,798.2 мянган төгрөгийн зарцуулж 19,973.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Авлага дансны үлдэгдэл 19,973.8 мянган төгрөг байгаа нь ахмадын сангийн үлдэгдлийг сангийн яам татан төвлөрүүлснийг авлагаар бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,310,556.2 мянган төгрөг болж 168,771.0 мянган төгрөг өссөн байна. Энэ нь төсвийн хөрөнгөөр 217,616.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн ЗДТГ болон аймгийн онцгой комиссоос 59,699.8 мянга, Онцгой байдлын Ерөнхий газраас 638,318.5 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авч 608,973.5 мянган төгрөгийн хөрөнгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 114,529.9 мянган төгрөгийг материалыг төсөвт байгууллагад шилжүүлэн, 23,360.4 мянган төгрөгийн бараа материалыг Онцгой байдлын газрын даргын 2025 оны А/81 дүгээр тушаалаар акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,279,873.22 мянган төгрөг болж 3,173,885.39 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь 1,790.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, ОБЕГ-ын даргын 2025 оны 08 дугаар 25-ны өдрийн А/319 дүгээр тушаалаар 2,943,794.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын автомеханик шат /автомашин/, 2025 оны 09 дүгээр 24-ны өдрийн А/373 дугаар тушаалаар 187,000.0 мянган төгрөгийн Ланд Круйзер авто машин 34,780.0 мянган төгрөгийн АБДТ-ын цэнэглэгч суурин компрессор, Баянцагаан сумын Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/55 дугаар Захирамжаар 19,720.0 мянган төгрөгийн газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагын хандиваар 3,559.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 355 дугаар тогтоолоор 32,222.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,100.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тайлант онд 3 алба хаагчид буцатлгүй тусламж олгох тухай шийдвэр боловч санхүүжилтийн эрх нээгдээгүйн улмаас ОБЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу өглөгөөр бүртгэсэн байна.

Баянхонгор аймгийн ОБГ-нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК -ны санхүүгийн тайлангийн Acolous, Payroll зэрэг программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд 2025 онд программын лицензийн төлбөрт 627.0 мянган төгрөгийг төлсөн байна. Мөн байгууллагын урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл байршуулах зориулалттай байгууллагын Цахим хуудасыг 2014 онд ОБЕГ-аас нэгдсэн байдлаар нэвтрүүлж байгууллагын бүртгэлд 800.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,858,849.4 мянган төгрөг болж 2,466,934.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 2,466,934.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,676,863.4 мянган тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 294,006.7 мянган төгрөгөөр бууруулж 4,382,856.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 4,791,902.3 мянган төгрөг болгож 115,038.9 мянган төгрөгөөр өсгөн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,791,902.3 мянган төгрөг батлагдсанаас 4,762,650.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,762,650.9 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 26,746.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80801 үндсэн үйл ажиллагаа зардал	4,769,190.80	4,742,714.48	26,476.32	99.4%
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	6,075.00	3,300.00	2,775.00	54.3%
3	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	636.50	636.40	0.10	100.0%
4	82310 Гамшигаас сэргийлэх сургалт, сурталчилгаа	16,000.00	16,000.00	0.00	100.0%
	Нийт дүн	4,791,902.30	4,762,650.88	29,251.42	99.4%

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 25,949.4 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 0.1 мянга нийт 25,949.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

1. Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь тайлант онд 135 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан ба тухайн онд орон тооны цомхотгол хийгээгүй байна.
2. Тайлант онд ОБЕГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар хоол, унааны нөхөх төлбөрийг шинэчлэн тогтоосон байна. Баянхонгор аймгийн ОБГ-нь шинэчлэгдсэн тарифын дагуу хооны хөнгөлөлтийг нэг алба хаагчид өдрийн 8.0 мянган төгрөгөөр тооцож гүйцэтгэлээр 121,312.0 мянган төгрөгийг олгосон бөгөөд батлагдсан төсвөөс 46,976.8 мянган төгрөгөөр хэтрүүлж цалингийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.
3. Гадаад томилолт, арга хэмжээний зардал гараагүй.
4. Сургалт, семинар, хурал зөвлөгөөн арга хэмжээний зардал гараагүй.
5. Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь тайлант онд гамшгаас хамгаалах болон урьдчилан сэргийлэх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгын хүрээнд хэвлэл мэдээллийн хоёр байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 16,000.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас санхүүжүүлэн хамтран ажилласан байна.. Үүнд:

Хүснэгт 1. Хамтран ажиллах гэрээний жагсаалт

/мянган төгрөгөөр/

Нэр	Регистрийн дугаар	Гэрээт ажлын нэр	Огноо	Хугацаа	Дүн	Гүйцэтгэл
Монголньюс ХХК / Өдрийн сонин/	2097397	Хамтран ажиллах гэрээ	2025.01.07	1 жил	10,000	10,000
МТД ХХК	2605899	Хамтран ажиллах гэрээ	2025.02.14	1 жил	6,000	6,000

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дараах орлого төвлөрсөн байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

/мян.төг/

Д/д	Орлогын нэр төрөл	Авсан санхүүжилт
1	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,906.96
2	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,945.50
3	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,290.00
Нийт дүн		82,142.62

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Дээрх орлогыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Ахмадын сангийн дансны эхний үлдэгдэл 52,772.0 мянган төгрөг байсан ба тайлант онд 32,798.2 мянган төгрөгийн зарцуулж 19,973.8 мянган төгрөгийг сангийн яаманд төвлөрүүлж авлагаар бүртгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь тайлант онд хүнс болон мах, махан бүтээгдэхүүн худалдан авахад 126,225.0 мянган төгрөгийн төсөв батлуулж, нээлттэй тендер шалгаруулах аргаар хоёр багц бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Нээлттэй тендерт мах махан бүтээгдэхүүн нийлүүлэх 1 оролцогч оролцож гэрээ байгуулсан бол хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 3 оролцогч оролцож “Далай ээж Баянхонгор” ХХК нь хамгийн бага үнийн санал ирүүлж 37,750.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан 6,071.9 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гаргасан байна.

Хүснэгт 2. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

/ мянган төгрөгөөр/

Оролцогч	Төрөл	Төсөвт өртөг	Ирүүлсэн үнийн санал	ХАА-ны төрөл	Гэрээ байгуулсан	Т-ийн хэмнэлт
Их Номгон баян ХХК	Хүнс	43,641.9	43,602.0	НТШ	0	0
Далай ээж Баянхонгор ХХК	Хүнс	43,641.9	37,570.0	НТШ	37,570.0	(6,071.9)
Софтвишин ХХК	Хүнс	43,641.9	38,170.0	НТШ		
Хүслэнт надин шагай	Мах	82,583.1	82,583.1	НТШ	82,583.1	-
Нийт дүн		0	120,153.05		120,153.05	(6,071.90)

Эх сурвалж: (Tender.gov.mn), худалдан авах ажиллагааны тайлан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр ирүүлсэн.

Тайлант оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Д.Бат-Эрдэнэ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Э.Баянзул нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлын 4,791,902.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 47,919.0 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 31,147.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2025 оны гэрэл цахилгааны зардлыг 541.6 мянга, түлш халаалтын зардлыг 16,781.6 мянга, цэвэр бохир усны зардлыг 87.6 мянга нийт тогтмол зардал 17,410.7 мянга буюу 6.5 хувь хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4,977,468.6 мянган төгрөгийн 20 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 148,817.3 мянган төгрөгийн 15 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 53,455.1 мянган төгрөгийн 65 мэдээллийг бүрэн байршуулахаас шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг “Баянхонгор аймаг дахь Төрийн аудит газар”-ын аудитор Н.Бүнчинсүрэн хийж гүйцэтгэсэн байна.

Аудитаар 67,145.1 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 67,145.1 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хүргүүлсэн ба тайлант онд хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	67,145.1	2	67,145.1	100
Нийт дүн	2	67,145.1	2	67,145.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн төслийг боловсруулах явцад хоолны хөнгөлөлтийн зардлыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулах, шинэчлэгдсэн тарифыг бүрэн тусган тооцоогүйгээс зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна. Иймд хоолны хөнгөлөлтийн зардлын тооцооллыг шинэ тариф болон гүйцэтгэлийн бодит түвшинд үндэслэн нарийвчлан төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсөв захирагчид хүргүүлэх шаардлага үүсэж байгаа бөгөөд энэ асуудлыг дараагийн аудитаар анхаарч хянан үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1 зөрчил илэрснээс, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн.¹

Нийт илрүүлсэн алдаа, зөрчилөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 31,147.4 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 11 төрлийн 179,059м² газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 2 газрын хэмжээ 85м²-аар байгууллагын балансад бүртгэлтэй хэмжээнээс зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэнтэй нийцэхгүй байна.

"Шийдвэрлэсэн нь: Газрын харилцаа, хот байгуулалтын газартай тооцоо нийлж зөрчлийг арилган хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 11 төрлийн 179,059м ² газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 2 газрын хэмжээ 85м ² -аар байгууллагын балансад бүртгэлтэй хэмжээнээс зөрүүтэй байна.	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-

-----oOo-----

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 79/57/1855/БМА-2026-60Э
- НА-СТА-725

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 11 төрлийн 179,059м² газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 2 газрын хэмжээ 85м²-аар байгууллагын балансад бүртгэлтэй хэмжээнээс зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Газрын харилцаа, хот байгуулалтын газартай тооцоо нийлж зөрчлийг арилган хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

6426090250

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын дарга Д.Бат-Эрдэн, нягтлан бодогч Э.Баянзул нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Д.ДАВААДОРЖ

6907143544
БЧ040067 9001423

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно